

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.01; 97.195

Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Соёлын төв, соёлын ордон. Орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага	MNS 6981:2022
Customer service. Cultural Center and Palace of Culture. Environment and general requirements for services	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 42 дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Соёлын төв, соёлын ордны үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуй нэгжид өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хамаарна.

Энэ стандартад “Соёлын төв, ордны” гэхийг цаашид “байгууллага” гэж дурдана.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд эш татсан хэвлэлийг хэрэглэх ба он заагаагүй тохиолдолд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ. Үүнд:

MNS 4968, *Эрүүл ахуй, Ерөнхий шаардлага;*

MNS 4990, *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага;*

MNS 4244, *Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;*

MNS 6423, *Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага;*

MNS 6767, *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага;*

MNS 5566, *Гал түймрээс хамгаалах. Аж ахуй нэгж, байгууллага, барилга, байгууламжид гал унтраах анхан шатны багаж, хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм;*

MNS 5390, *Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;*

MNS 5283 *Гудамж, зам талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавигдах ерөнхий шаардлага;*

MNS 6981:2022

MNS 6476, Мэргэжлийн урлагийн байгууллагын орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага.

MNS 0900, Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага. Чанар, аюулгүйн байдлын үнэлгээ;

MNS 5634, Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага;

MNS 5742, Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага.

3 Нэр томъёоны тодорхойлолт

Энэ стандартад дараах нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

соёлын төв, соёлын ордон

хүний оюуны эрэлт хэрэгцээг хангах, соёлын үйлчилгээ үзүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага

ТАЙЛБАР: Дээрх чиг үүргийг гүйцэтгэж буй байгууллагыг соёлын төв, соёлын ордон зэргээр нэрлэсэн байдаг. Нэршлийг үүсгэн байгуулагч нь соёлын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн баталж болно. Холбогдох хуульд соёлын төв, соёлын ордон гэж зохицуулсан байх тул хуулийн нэрээр уг стандартыг нэрлэв.

3.2

сургалтын үйл ажиллагаа

бүтээн туурвих үйл ажиллагааны өмнөх болон дагалдуулан сургах, соёлын боловсролоор дамжуулан авьяас хөгжүүлэх сургалтын үйл ажиллагаа

3.3

соёлын үйлчилгээний хэрэглэгч

соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг захиалах, худалдан авах, ашиглахыг хүссэн хуулийн этгээд, хувь хүн

3.4

энтертайнмент үйлчилгээ

үзэгчдэд гоо зүйн таашаал өгөх, сонирхлыг татахуйц хэлбэрээр хүн амын чөлөөт цаг чиглэгдсэн соёл, чөлөөт цагийн үйл ажиллагааны нэг хэлбэр

4 Ерөнхий шаардлага

4.1 Барилга байгууламжид тавих шаардлага

4.1.1 Байгууллага нь соёлын үйлчилгээ үзүүлэхэд тохиромжтой (нийслэлийн хувьд нийтийн тээврийн буудал, явган хүний гарцтай ойр) байршилтай байна.

4.1.2 Хөгжлийн хэтийн төлөвлөлт, хөгжлийн ирээдүйтэй бүс, нутаг дэвсгэрийн хүн амын нягтрал зэргийг харгалзан соёлын төвийн барилга, байгууламжийн хүчин чадлыг тогтооно. (Хавсралт А)

4.1.3 Байгууллага нь эрх бүхий байгууллагаас баталсан барилгын зураг төслийн дагуу баригдсан барилга, байгууламжтай байна. (Хавсралт В)

4.1.4 Байгууллага нь хүчин чадалдаа тохирсон тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангагдсан байна. (Хавсралт С)

4.1.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, галын аюулгүй байдал, гэнэтийн ослоос сэргийлэх, эрүүл ахуйн талаар тогтоосон стандартын шаардлагыг хангасан, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсээс хамгаалагдсан байхыг шаардана.

4.1.6 Байгууллага нь өөрийн загвар, дүр төрхтэй байх ба хаяг, цагийн хуваарийг хэрэглэгчид харагдах газарт байршуулна. (Хавсралт D)

4.1.7 Байгууллагын гадна болон дотор талд үйл ажиллагаа явуулах хүчин чадалд хүрэхүйц цахилгааны эх үүсвэртэй байна.

4.1.8 Байгууллагын цахилгаан ба холбогдох тоног төхөөрөмжийг тухайн чиглэлээр мэргэшсэн ажилтнаар тохируулах, шалгах, засварлах ажлыг гүйцэтгүүлнэ.

4.1.9 Байгууллага нь анхан шатны тусламж үзүүлэх эрүүл мэндийн хэрэгсэлтэй, хэрэглэхэд ойр газар хадгалалтын горимд хадгална.

4.2 Байгууллагын гадна орчинд тавих шаардлага

4.2.1 Байгууллагын эдэлбэр газар нь гадна талбайдаа үйлчилгээний, аж ахуйн, амралтын, авто тээврийн хэрэгслийн зогсоол, ногоон байгууламж, тоглоомын талбай зэргийг төлөвлөсөн байна.

4.2.2 Байгууллагын эдэлбэр газар нь кадастрын зураг, газар эзэмших гэрчилгээгээр баталгаажсан байна.

4.2.3 Экологийн шийдэл бүхий байж болно.

4.2.4 Эдэлбэр газрын нийт талбайгаас барилга байгууламжийн талбайд ноогдох хэмжээ нь 1/3 байна.

4.2.5 Барилгын гадна талд гэрэлтүүлэгтэй байна. Гэрэлтүүлэгт сэргээгдэх эрчим хүчний технологийг ашиглаж болно.

4.2.6 Барилгын гадна талд байгууламжийн хүчин чадалтай уялдуулсан авто тээврийн хэрэгслийн зогсоолыг холбогдох стандартын дагуу төлөвлөнө.

4.2.7 Барилгын гадна зам, талбайн, гадаргууг цас, бороонд халтирахгүй зориулалтын материалаар хийсэн байна.

4.2.8 Тусгай хэрэгцээт иргэд, ахмад настан болон хүүхдийн тэрэгтэй зорчиход саадгүй шат, налуу замыг стандартын дагуу хийсэн байна.

4.2.9 Галын аюулгүй болон гэнэтийн ослын үед баримтлах стандарт, дүрэм, журмыг мөрдлөг болгоно.

4.2.10 Барилга нь байгалийн болон хиймэл агаар сэлгэлтийг тооцсон байна. Цонхны салхивчийг 45 градуссаас багагүй онгойдог байна.

4.2.11 Барилгын байршлаас шалтгаалан үерийн усны аюулаас хамгаалах байгууламжтай байна.

4.2.12 Аваарын (ослын) гарцын тэмдэглэгээ нь байрлал, загвар, өнгөний хувьд бусад хаяг тэмдэглэгээнээс ялгарахуйц байна. Ослын гарц, яаралтай тусламжийн тэмдэглэгээ, багаж хэрэгсэлтэй байна.

4.2.13 Яаралтай тусламж (гал түймэр, эмнэлгийн түргэн тусламж) саадгүй нэвтрэхээр байна.

4.3 Байгууллагын үйлчилгээний байранд тавих шаардлага

4.3.1 Үзвэр, үйлчилгээний танхим, өрөөнд дууны, дүрсний техник, гэрэлтүүлэг, дуу чимээ шингээх материалаар тоноглогдсон байна.

ТАЙЛБАР: 40-өөс багагүй инчийн 2 дэлгэцийг үзэгчийн танхимд байрлуулж болно.

4.3.2 Үзэгчийн танхимын дууны хүчдэл 96 дБ, хөгжмийн дуугаралт 100 дБ-ээс хэтрэхгүй байна.

4.3.3 Үүдний хүлээлгийн танхим хэсэгт тасалбар болон хүнсний бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу худалдаалж болно.

4.3.4 Үүдний хүлээлгийн танхимд үзэгчийн суудлын хүчин чадлын 10 хувьтай дүйцэхүйц сандал байрлуулна.

4.3.5 Цэвэр бохир усны төвлөрсөн болон хэсгийн системд холбогдсон, шугам хоолой нь стандартын шаардлагад нийцсэн байна.

4.3.6 Шал нь халтирдаггүй шатамхай бус (галд тэсвэртэй) материалаар хийгдсэн байна.

4.3.7 Үзэгчийн танхим, өрөө тасалгаа нь агааржуулалтын системтэй байна.

4.3.8 Механик салхивчийн системийг хуваарийн дагуу ажиллуулж, зохих засвар үйлчилгээг хийнэ.

4.3.9 Үйлчлүүлэгчийн хувцасны өлгүүр нь үзэгчийн танхимтай ойрхон, хөдөлгөөний урсгал дагуу байрласан байна.

4.3.10 Барилга байгууламжийн энгийн температур нь багадаа +18 хэм, агаарын харьцангуй чийгшил 50% байхаар инженерийн шийдлийг төлөвлөнө.

4.3.11 Хэрэглэгчдэд зориулсан 3G-ээс дээш үзүүлэлт бүхий интернэттэй байна.

4.3.12 Ариун цэврийн өрөөний хэмжээ, талбайг Олон нийтийн барилга байгууламж БНБД 31-03, Захиргаа, аж ахуйн барилга БНБД-г үндэслэн төлөвлөнө.

4.4 Байгууллагын үйлчилгээнд тавих шаардлага

4.4.1 Энэ стандартад дурдагдаж байгаа байгууллагын нэршлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэршил, зэрэглэл, ангиллыг журамлан тогтоож болно.

4.4.2 Байгууллага нь хувь хүний соёлын боловсролыг дэмжин хөгжүүлэх, орон нутгийн байгаль түүх, соёлын үнэт зүйлийг сурталчлах, номын сан, музейн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий соёл, мэдээллийн төв байна. (Хавсралт Е)

4.4.3 Байгууллага нь дэргэдээ номын сангийн үйлчилгээ үзүүлнэ. “MNS 5742:2019 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага”-аар зохицуулна.

4.4.4 Байгууллага нь дэргэдээ музейтэй байж болно. Музейн стандартаар зохицуулна.

4.4.5 Байгууллага нь хууль тогтоомжоор хүлээлгэсэн санхүүгийн зарим эх үүсвэрийг бүрдүүлэхэд төлбөртэй сургалт, үйлчилгээг үзүүлж болно.

ТАЙЛБАР: Судалгаанд суурилсан эдийн засгийн үндэслэлтэй байна.

4.4.6 Соёлын боловсрол олгох сургалтыг багш, удирдагч чиглүүлнэ. (жишиг хугацааг 1 дүгээр хүснэгтээс үзнэ үү).

1-р хүснэгт - Сургагч багшийн сургалтын хугацаа

Оролцогчдын нас	Хичээллэх хугацаа	Үргэлжлэх хугацаа
Сургуулийн өмнөх ба сургуулийн бага ангийн насны	7 хоногт 2 удаа	45 минут
Сургуулийн дунд ахлах насны	7 хоногт 2-3 удаа	10 минутын завсарлагатай 90 мин
Насанд хүрэгчид	7 хоногт 2-3 удаа	10 минутын завсарлагатай 90 мин

4.4.7 Нөхцөл байдлаас шалтгаалан сургалтын хичээллэх хугацааг богиносгосон цагаар болон цахимаар хичээллэж болно.

MNS 6981:2022

4.4.8 Насанд хүрээгүй хүнд үйлчилгээ үзүүлэх цагийн болон насны хязгаарыг холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн тогтооно.

4.4.9 Архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн, төлбөртэй үйлчилгээний үед тасалбаргүй (зөрчилтэй тасалбартай) иргэдэд үйлчилгээ үзүүлэхээс татгалзана.

4.4.10 Дайн, түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үзвэр, үйлчилгээ үзүүлэх, утга зохиол, ном, хэвлэл тараахыг хориглоно.

4.4.11 Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаж, цэвэрлэгээ үйлчилгээ, халдваргүйтгэл, шавж, мэрэгч устгалын үйл ажиллагааг тогтмол хийж гүйцэтгэнэ.

4.5 Байгууллагын хүний нөөцөд тавих шаардлага

4.5.1-Байгууллага нь хууль ёсны зорилгоо хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, орон тоотой байна.

4.5.2 Байгууллагын орон тоог үйл ажиллагааны үндсэн чиглэл, гүйцэтгэлийн гол үзүүлэлт, үр дүн, байгууламжийн хүчин чадал зэргийг харгалзан тогтооно. (Хавсралт F)

4.5.3 Байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэхдээ тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага хангасан иргэнийг томилно.

4.5.4 Байгууллагын удирдлага (үүсгэн байгуулагч) нь ажиллагчдыг нийгмийн баталгаагаар хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, залуу мэргэжилтнүүд болон үр бүтээлтэй ажиллаж буй ажиллагчдад дэмжлэг үзүүлнэ.

4.5.5 Соёлын байгууллагын удирдлага, багш, ажилтнууд нь 5 жил тутам 1-ээс доошгүй удаа мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдана.

Тайлбар: Дадлага сургалт - 72 цагаас, мэргэжил дээшлүүлэх курс - 96 цагаас багагүй байна.

ТӨГСӨВ.

А хавсралт
(мэдээллийн)

**Байгууллагын барилга байгууламжийн
хүчин чадлыг тооцох хэм хэмжээ**

Оршин суугаа хүн ам	Хүчин чадал (үзэгчийн суудал)
1000 хүртэл хүн амтай	160
1001-ээс 3000 хүн амтай	250
3001-ээс 5000 хүн амтай	350
5001-ээс 15000 хүн амтай	400
15001-ээс 50000 хүн амтай	500
50001-ээс 100000 хүн амтай	600
100001-ээс 250000 хүн амтай	Хэрэгцээ шаардлагатай уялдуулж хүчин чадлыг тооцож болно.
250000-ээс 500000 хүн амтай	
500000-ээс дээш хүн амтай	

1-Р ТАЙЛБАР: Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1 дэх хэсэг “Сумдын хөгжлийн загвар”-ыг 1001-15000 хүн амтай нутаг дэвсгэрт баримтална.

2-Р ТАЙЛБАР: Тухайн бүс нутгийн хөгжлийн хандлага, төлөвлөлттэй уялдуулж барилга, байгууламжийн хүчин чадлын тогтоосон ба ашиглалтын зардал жилийн турш үйлчилгээ явуулах эдийн засаг болон инфляцын ханштай харьцуулан тооцно.

3-Р ТАЙЛБАР: Энэхүү стандартаар тогтоосон тоо хэмжээ нь холбогдох үзүүлэлтээс шалтгаалан хэлбэлзэж болно.

В хавсралт
(мэдээллийн)

**Байгууллагын барилга байгууламжийн
төлөвлөлтөд тавих шаардлага**

**В.1 Байгууллагын хүчин чадлаас хамааран барилга байгууламжийн
төлөвлөлтөд тавих шаардлага**

В.1.1 Үзэгчийн танхимын таазны өндрийг 4,0 м-ээс багагүй, танхимаас бусад хэсгийн таазны өндрийг 2,8 м-ээс багагүй байхаар төлөвлөнө.

В.1.2 Хонгил нь 2,0 м-ээс дээш өргөнтэй байна. Үзэгчийн танхимын тайзнаас суудлын 1 дүгээр эгнээ хүртэлх зай нь 2,0 м-ээс 4,0 м-ийн хооронд байна.

В.1.3 Үзэгчийн танхим нь дуу намсгагч бүхий материалаар тоноглогдсон байна.

В.1.4 Үзэгчийн танхимын 1 дүгээр эгнээнд эсвэл эгнээний урд тэргэнцэр, тэрэгтэй иргэдэд зориулсан тусгай талбайтай, тэмдэг тэмдэглэгээтэй байна.

В.1.5 Үзэгчийн танхимын суудлын эгнээ хоорондох зай нь 0,45 м-ээс багагүй, суух өргөн нь 0,52 м, гүн нь 0,45 м, налуургын өндөр нь 0,50 м-ээс багагүй байна.

В.1.6 Үзэгчийн танхим нь 2-оос дээш гарцтай байна.

В.1.7 Үзэгчийн танхимын хоёр талын хананд гэрэлтүүлгийн тагттай байна.

В.1.8 Байгууллага нь дэргэдээ дууны болон видео студийг төлөвлөж болно.

В.1.9 Бэлтгэлийн өрөөг душ, ариун цэврийн өрөөтэйгөөр төлөвлөнө.

В.1.10 Олон нийтэд зориулсан эрэгтэй, эмэгтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөг 6 хүнд 1 угаагуур, 70 эрэгтэй тутамд 1 суултуур, 2 хөтөвч, 30 эмэгтэй тутамд 1 суултуур байхаар тооцож төлөвлөнө. Нэг кабины өргөн 0,9 м-ээс багагүй, 1,2 м-ээс багагүй урттай, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан кабины хэмжээ 1,65 м-ээс багагүй өргөнтэй, 1,8 м-ээс багагүй урттай байна.

В.1.11 Байгууллага нь 300-аас дээш хүний суудалтай бол байгууламжийг дараах байдлаар төлөвлөнө.

В.1.11.1 Үзэгчийн танхимын таазны өндрийг 6,0 м-ээс дээш, шал нь шаталсан налуу байна.

В.1.11.2 Үзэгчийн танхим нь 2-оос доошгүй суудлын эгнээтэй байна.

В.1.11.3 Бүжгийн танхимыг тусад нь төлөвлөнө.

В.1.11.4 40-өөс доошгүй суудалтай бель-этаж төлөвлөнө.

**В.1-р хүснэгт - Барилга байгууламжийн төлөвлөлтөд
тусгах өрөө, танхим**

№	Байгууламжид төлөвлөгдөх хэсэг	Хүчин чадал (үзэгчийн суудлаар)				
		250 хүртэлх	251-ээс 350	351-ээс 400	401-ээс 500	501-ээс 600
Үзвэр, үйлчилгээний танхимын төлөвлөлт						
1	Үзэгчийн танхим	+	+	+	+	+
2	Бүжгийн танхим	-	+	+	+	+
3	Хөгжмийн сургалтын танхим	+	+	+	+	+
4	Бүжгийн сургалтын танхим	+	+	+	+	+
5	Кино үзлэгийн өрөө	-	-	+	+	+
6	Дууны техникийн удирдлагын өрөө	+	+	+	+	+
7	Гэрэлтүүлгийн удирдлагын өрөө	+	+	+	+	+
8	Бэлтгэлийн өрөө	+	+	+	+	+
9	Соёлын үйлдвэрлэлийн танхим /гэр бүлийн танхим	+	+	+	+	+
10	Орон нутаг судлах танхим	+	+	+	+	+
11	Үзмэрийн сан хөмрөгийн өрөө	+	+	+	+	+
12	Нийтийн уншлагын танхим	+	+	+	+	+
13	Төрөлжсөн уншлагын танхим	-	-	+	+	+
14	Цахим уншлагын танхим	±	±	+	+	+
15	Номын санчийн өрөө	+	+	+	+	+
16	Номын фондын өрөө	+	+	+	+	+
Бусад өрөө тасалгааны төлөвлөлт						
17	Даргын өрөө	+	+	+	+	+
18	Багш, ажилтнуудын өрөө	-	-	+	+	+
19	Үйлчилгээний ажилтны өрөө (ажиллагчдын тооноос хамаарах)	+	+	+	+	+
20	Хувцас солих өрөө	+	+	+	+	+
21	Хувцас хадгалах өрөө					
22	Архивын өрөө	+	+	+	+	+
23	Ариун цэврийн өрөө (эр, эм)	+	+	+	+	+
24	Дохиолол, серверийн өрөө	±	±	±	+	+
25	Хүндэт зочин хүлээн авах өрөө	±	±	±	±	±
26	Тусгаарлах өрөө	+	+	+	+	+
27	Буфет	±	±	±	±	±
28	Тасалбар борлуулах цэг	+	+	+	+	+
29	Хүлээлгийн танхим	+	+	+	+	+
30	Өлгүүр	+	+	+	+	+

ТАЙЛБАР:

- + Заавал шаардлагатай
- ± Заавал шаардлагагүй, хавсарч гүйцэтгэж болох
- Шаардлагагүй

MNS 6981:2022

В.2 Соёлын төвийн тайзанд тавих шаардлага

В.2.1 Тайзны шалны арын захаас 40-50 см-ийн зайд 80 см өргөнтэй шалны түвшингээс дээш 0,8-1 м ба 1-1,2 м өндөрт хоёр үеэр шаталж өргөгддөг мөн шалны түвшинд буцаж хураагддаг хөдөлгөөнт тавцан төлөвлөж болно.

В.2.2 Тайзны хоёр тал (кулис)-аас тайзны ар (задник)-аар хүн явах хонгил нь 1,5 м-ээс доошгүй өргөнтэй байна.

В.2.3 Соёлын төвийн тайзыг галерейтай төлөвлөж болно. (*тайзны хөшиг, заслыг тайзнаас дээш өргөх орон зайтай байх*)

В.2.4 Тайз руу хөгжим, гэрэлтүүлэг болон том оврын тайзны засал, тоног төхөөрөмжийг машинаас шууд зөөвөрлөн оруулах, буцаан гаргах боломжтойгоор хаалга, пандустай байхыг зөвлөнө.

В.2.5 Тайзны хөдөлгөөнт механизмуудад орчин үеийн нэгдсэн удирдлагаар ажиллах технологийг тусгана.

В.2.6 Тайзны талбайн хэмжээ нь үзэгчийн танхимын талбайн хэмжээнээс 1/3-ээс доошгүй байна.

В.2.7 Соёлын төвийн тайзны хэмжээг үзэгчийн суудлын хүчин чадлаас хамааран В.2-р хүснэгтэд зааснаар тогтооно.

В.2-р хүснэгт - Тайзны хэмжээ

Хүчин чадал	Өргөн	Гүн	Өндөр	
			Тайзнаас таазны өндөр	Шалнаас тайзны өндөр
300 хүртэлх	14 м	12 м	7 м	0,80-1 м
600 хүртэлх	16 м	14 м	9 м	0,80-1 м

1-Р ТАЙЛБАР: Тайзыг байгууламжийн архитектурын шийдлээс хамааран өөрөөр төлөвлөгдөж болно.

2-Р ТАЙЛБАР: Барилга, байгууламжид төлөвлөгдөх хэмжээ, талбайг Олон нийтийн барилга байгууламж БНБД 31-03, Захиргаа, аж ахуйн барилга БНБД -г үндэслэн төлөвлөнө.

С хавсралт
(Мэдээллийн)

Байгууллагын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жишиг

№	Тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт	Хүчин чадал (үзэгчийн суудлаар)				
		250 хүртэлх	251-ээс 350	351-ээс 400	401-ээс 500	501-ээс 600
Хөгжим, техник						
1	Яригч (шингэн,ср)	4 ш (1000w)			6 ш (1000w)	
2	Яригч (нам,басс) (2000 BT дээш)	2 ш (500w)			4 ш (500w)	
3	Яригч (заалны араас нам, шингэн дуугарах нэмэлт яригч)	2 ш (500w)			2 ш (500w)	
4	Монитор яригч	2 ш (500w)			2 ш (500w)	
5	Зурвас хуваарилагч	+	+	+	+	+
6	Мульт кабель	+	+	+	+	+
7	Пульт	24 замтай			24 замтай	
8	Чадлын өсгөгч	3 ш (1200w)			4 ш (1200w)	
9	Чадлын өсгөгч (мониторын)	1 ш (1200w)			1 ш (1200w)	
10	Микрофон (утасгүй)	2 ш			2 ш	
11	Микрофон (утастай)	4 ш			4 ш	
12	Микрофон (хөгжим)	+	+	+	+	+
13	Микрофон (хөл)	+	+	+	+	+
14	Холбогч кабелууд	+	+	+	+	+
15	Микрофоны кабелууд	+	+	+	+	+
16	Яригчийн кабелууд	+	+	+	+	+
17	Зөөврийн уут (яригч)	+	+	+	+	+
18	Зөөврийн хайрцаг (яригч)	+	+	+	+	+
19	Зөөврийн хайрцаг (пульт)	+	+	+	+	+
20	Зөөврийн хайрцаг (чадал)	+	+	+	+	+
21	Уртасгагч залгуурууд	+	+	+	+	+
22	Үндэсний хөгжмийн зэмсгүүд	+	+	+	+	+
23	Цахилгаан хөгжмийн зэмсгүүд	+	+	+	+	+
24	Үлээвэр хөгжмийн зэмсгүүд	+	+	+	+	+
25	Сонгодог хөгжмийн зэмсгүүд	±	±	+	+	+
Гэрлийн тоног төхөөрөмж						

MNS 6981:2022

26	Мак шарпы гэрэл (лэд нь эргэдэг), (380 ВТ дээш)	16 ш (380w)		20 ш (380w)		
27	Паар гэрэл (лэд) (500-1000 ВТ дээш)	30 ш (500w)		40 ш (500w)		
28	Пүшикийн гэрэл (500-1200 ВТ дээш)	1 ш (1200w)		1 ш (1200w)		
29	Чимэглэлийн гэрэл (500-1000 ВТ дээш)	±	±	+	+	+
30	Пульт	+	+	+	+	+
31	Дас лайт	+	+	+	+	+
32	Тог баригч	+	+	+	+	+
33	Демер	+	+	+	+	+
34	Холбогч кабелууд	+	+	+	+	+
35	Зөөврийн хайрцаг /гэрэл/	+	+	+	+	+
36	Зөөврийн компьютер	+	+	+	+	+
Лэд дэлгэц						
37	Лэд дэлгэц (P5-P2,5 хооронд гадна болон дотор)	3*5 (15 м2, 3,91 рхл 1 блок нь 0,5*0,5 харьцаатай)		3*5 (15 м2, 3,91 рхл 1 блок нь 0,5*0,5 харьцаатай)		
38	Лед дэлгэцийн суурь	хэмжээгээрээ		хэмжээгээрээ		
39	PC компьютер	+	+	+	+	+
40	Send box card	+	+	+	+	+
41	Чадал баригч	+	+	+	+	+
42	380ВТ тог баригч	+	+	+	+	+
43	Холбогч кабелууд	+	+	+	+	+
44	Зөөврийн хайрцаг (дэлгэцийн)	+	+	+	+	+
45	Зөөврийн хайрцаг (Send box card)	+	+	+	+	+
46	Зөөврийн хайрцаг (Чадал баригч)	±	+	+	+	+
47	Зөөврийн хайрцаг (380ВТ тог баригч)	±	+	+	+	+
48	Зөөврийн хайрцаг (Холбогч кабелууд)	±	+	+	+	+
Тайзны хөшиг						
49	Төв хөшиг	1 эгнээ				
50	Горизонт арын хөшиг	1 эгнээ				
51	Тюль хөшиг	1 эгнээ				
52	Кулис	3 эгнээ		3-4 эгнээ		

53	Штангет	Хөшигний зам 6 эгнээ, гэрлийн зам 3 эгнээ		Хөшигний зам 6-8 эгнээ, гэрлийн зам 3 эгнээ		
54	Гэрлийн суурь	+	+	+	+	+
Тоног төхөөрөмж						
55	Суурин компьютер	3 ш-ээс дээш		5 ш-ээс дээш		
56	Зөөврийн компьютер	3 ш-ээс дээш		5 ш-ээс дээш		
57	Принтер (хар)	+	+	+	+	+
58	Принтер (өнгөт)	+	+	+	+	+
59	Сканнер	+	+	+	+	+
60	Канон	+	+	+	+	+
61	Проектор	HD болон 4K өргөтгөлтэй				
62	Проектор дэлгэц	HD болон 4K дэмждэг				
63	Цүнх (проектор)	+	+	+	+	+
64	Холбогч кабелиуд	+	+	+	+	+
65	Зургийн аппарат	+	+	+	+	+
66	Wi-fi төхөөрөмж	+	+	+	+	+
67	Телевизор	+	+	+	+	+
68	Кино техникийн хэрэгсэл	+	+	+	+	+
69	Нүүдлийн цахилгаан үүсгэвэр	+	+	+	+	+
70	Цахим арга хэмжээг шууд дамжуулах, архивлах видео камер	+	+	+	+	+
71	Теле хяналтын системийн камер	+	+	+	+	+
72	Синхрон орчуулгын чихэвч	±	±	±	±	±
73	Синхрон орчуулгын микрофон	±	±	±	±	±
74	Синхрон орчуулгын холбоос утаснууд	±	±	±	±	±
75	Синхрон орчуулгын кабин	±	±	±	±	±
76	Синхрон орчуулгын wifi цацагч	±	±	±	±	±
Тайзны салют, утааны төхөөрөмж						
77	Тайзны салют (галан)	±	+	+	+	+
78	Тайзны салют суурь	±	+	+	+	+
79	Тайзны салютын удирдлага (wi-fi)	±	+	+	+	+
80	Тайзны арын фоны бороон салют (галан)	±	+	+	+	+

MNS 6981:2022

81	Тайзны арын фонын бороо (усан)	±	+	+	+	+
82	Тайзны цас	±	+	+	+	+
83	Тайзны салютын холбоос утаснууд	±	+	+	+	+
84	Зөөврийн тайзны салютын сууринууд	±	+	+	+	+
85	Зөөврийн тайзны салютын холбоос утас	±	+	+	+	+
86	Зөөврийн тайзны утаан салют	±	+	+	+	+
87	Тайзны утаа (хүнд)	±	±	+	+	+
88	Тайзны утааны (шингэн)	±	±	+	+	+
89	Зөөврийн тайзны утаа	±	±	+	+	+
90	Зөөврийн тайзны утааны (шингэн)	±	±	+	+	+
Нэмэлт хэрэгсэл						
91	Карказ	±	±	±	±	+
92	Зөөврийн нэмэлт тайз	±	±	±	±	+
93	Тусгаарлах шон	±	±	±	±	+
94	Зөөврийн нэмэлт тайзны шат	±	±	±	±	+
95	Асар (зөөврийн)	±	±	±	±	+
96	Падастовка	±	±	±	±	+
97	Тугны суурь	±	±	±	±	+
Тавилга, хэрэгсэл						
98	Ажлын ширээ, сандал	албан хаагч бүрд				
99	Албан хэргийн шкаф	албан хаагч бүрд				
100	Архивын сейф	+	+	+	+	+
101	Номын сангийн номын тавиур	+	+	+	+	+
102	Номын сангийн гүйдэг тавиур	±	±	+	+	+
103	Ном зөөдөг тавиуртай тэрэг	±	±	+	+	+
104	Каталогийн шүүгээ	+	+	+	+	+
105	Номын үзэсгэлэнгийн тавиур	+	+	+	+	+
106	Уншигчийн ширээ	+	+	+	+	+
107	Уншигчийн сандал	+	+	+	+	+
108	Цахим номын сангийн хэрэгсэл	+	+	+	+	+
109	Үзмэр хадгалах шилэн хорго	+	+	+	+	+
110	Үзмэрийн үзэсгэлэнгийн тавиур	+	+	+	+	+
111	Үзэгчийн сандал	+	+	+	+	+

Соёлын боловсролын сургалтын танхим						
112	Систем хөгжим	+	+	+	+	+
113	Даралтат хөгжим (пианино)	+	+	+	+	+
114	Ноотны самбар	+	+	+	+	+
115	Багшийн ширээ	+	+	+	+	+
116	Багшийн сандал	+	+	+	+	+
117	Ноотны тавиур	+	+	+	+	+
118	Чихэвч	+	+	+	+	+
119	Шүүгээ	+	+	+	+	+
120	Суралцагчийн ширээ	+	+	+	+	+
121	Суралцагчийн сандал	+	+	+	+	+
122	Систем хөгжим (аудио, видео)	+	+	+	+	+
123	Телевиз	±	±	±	+	+
124	Дасгалын толь (2 талдаа)	+	+	+	+	+
125	Тулгуур мод	+	+	+	+	+
126	Хувцасны шүүгээ (таславчтай)	+	+	+	+	+
127	Зориулалтын хулдаастай болон будаггүй шал	+	+	+	+	+
128	Урт вандан сандал	+	+	+	+	+

1-Р ТАЙЛБАР:

- + Заавал шаардлагатай
- ± Заавал шаардлагагүй, хавсарч гүйцэтгэж болох
- Шаардлагагүй

2-Р ТАЙЛБАР: 600-с дээш суудлын хүчин чадалтай байгууллагыг энэхүү жишгээр зохицуулах боломжгүй.

3-Р ТАЙЛБАР: Хөгжмийн хичээлийн танхимын суралцагчийн ширээ нь 1 ээлжид хичээллэх 2 суралцагчийн дунд 1, суралцагчийн сандал 1 ээлжид хичээллэх суралцагчийн тоогоор, бүжгийн хичээлийн танхимын ханын толь нь сургалтын өрөөний хананд параллель байрлалтай, танхимын тулгуур мод нь 1 хана дагуу, шалны хэмжээгээр зориулалтын хулдаастай эсвэл будаггүй, халтирдаггүй байна.

D хавсралт
(Мэдээллийн)

Байгууллагын загвар, дүр төрхийг бүрдүүлэхэд тавих жишиг

D.1 Байгууллага нь үйлчилгээний онцлог шинжийг агуулсан загвар, эерэг дүр төрхийг бүрдүүлнэ.

D.1.1 Логотой байна. Брэндбүүк, тугтай байна.

D.1.2 Нэр, нэрийн товчлолтой байна.

D.1.3 Алсын хараа, эрхэм зорилготой байна.

D.1.4 Байгууллагын үзэл баримтлал, үнэт зүйлийг тодорхойлно.

D.1.5 Ажиллагчид нь овог нэр, албан тушаалын нэр бүхий энгэрийн тэмдэг, үнэмлэхтэй байна.

D.2 Барилгыг архитектурын шийдэл бүхий бүс нутгийн онцлогийг тусган загварчлан бүтээж болно.

D.3 Байгууллагын ойролцоох орчны тохижилт, цэвэр байдлыг бүрдүүлнэ.

D.4 Барилгын гадна, нүүрэн талд байгууллагын нэр, логог өдөр, шөнийн аль ч цагт харагдахуйцаар байрлуулна.

D.5 Барилгын нүүрэн талын үүдний хэсэгт байгууллагын нэр, лого, хаягийг монгол бичиг, кирилл бичгээр хаягжуулна.

D.6 Байгууллагын үйлчилгээний мэдээллийг агуулсан зориулалтын дуу, дүрсний дэлгэц эсхүл самбарыг барилгын гадна, дотор талд зохих хэмжээтэй байрлуулна.

C.7 Байгууллагын үйл ажиллагааг цахим платформыг хөгжүүлнэ.

Е хавсралт
(Мэдээллийн)

Байгууллагын үйлчилгээнд тавих шаардлага

Е.1 Нас, хүйс, үндэс угсаа, боловсрол, улс төрийн үзэл, шашин шүтлэг, нийгмийн байдлыг үл харгалзан бүх нийтэд соёлын үйлчилгээ үзүүлнэ.

Е.2 Байгууллагын үйлчилгээний төрөл, хэлбэр нь Е.1-р хүснэгтэд заасны дагуу байна.

Е.1 -р хүснэгт - Байгууллагын үйлчилгээний төрөл, хэлбэр

№	Үйлчилгээний төрөл, хэлбэр	Хүчин чадал (үзэгчийн суудлаар)				
		250 хүртэлх	251-ээс 350	351-ээс 400	401-ээс 500	501-ээс 600
Нэг. Соёлын үйлчилгээ						
1	Гэр бүлийн хүрээн дэх соёлын үйлчилгээ	Жилд 8-аас доошгүй бие даасан болон сум, дүүрэг дундын хамтарсан байдлаар				
2	Эрүүл мэндийн соёлын үйлчилгээ					
3	Зан үйлийн наадам, фестиваль					
4	Хөдөлмөр, урлаг спортын баяр					
5	Баяр, наадам тэмдэглэлт өдрүүд	Жилд 60-аас доошгүй урлагийн тоглолт, үзвэр үйлчилгээ	Жилд 80-аас доошгүй урлагийн тоглолт, үзвэр үйлчилгээ			
6	Урлагийн тоглолт					
7	Нийтийн цэнгүүн					
8	Хобби бүлгүүд	3-аас доошгүй				
9	Үзэсгэлэн (номын үзэсгэлэн, түүх соёлын хөдлөх дурсгалт зүйл (үзмэр)-ийн үзэсгэлэн, бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид, гар урчуудын үзэсгэлэн г.м)	Жилд 5-аас доошгүй удаа				
10	Нүүдлийн соёлын үйлчилгээ: ахуйн үйлчилгээ, худалдаа, соёл, урлагийн болон соён гэгээрүүлэх үйлчилгээ	Жилд 4-өөс доошгүй удаа				
11	Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан соёлын үйлчилгээ	+	+	+	+	+
12	Залуучуудын хөгжлийг дэмжихэд чиглэсэн соёлын үйлчилгээ	4-өөс доошгүй бүтээлч ажил зохион байгуулах				
13	Ахмад настанд чиглэсэн соёлын үйлчилгээ	Жилд 2-оос доошгүй ажил зохион байгуулах				
14	Хууль, эрх зүй мэдлэг хамгаалахад чиглэсэн соёлын ажил	Жилд 4-өөс доошгүй ажил зохион байгуулах				
15	Иргэнийг төлөвшүүлэх соёлын үйлчилгээ: Эх оронч үзлийг төлөвшүүлэх, Гоо зүйн хүмүүжил,	+	+	+	+	+
16	Хүүхдэд чиглэсэн соёлын үйлчилгээ	+	+	+	+	+

Хоёр. Соёлын боловсролын үйлчилгээ						
1	Кино үзвэр	±	±	+	+	+
2	Номын сан (суурин)	Жилд 7800-аас доошгүй ном олгож, 500-аас доошгүй хүнд				
3	Номын сан (зөөврийн)	+	+	+	+	+
4	Ном, бичиг хэргийн худалдаа	±	±	+	+	+
5	Авьяас хөгжүүлэх сургалт (Урлагийн төрлүүд, амьдрах ухааны г.м)	Жилд 5-аас доошгүй төрлийн дугуйлан хичээллүүлж 100-аас доошгүй хүүхэд, залуучуудад үйлчилнэ.				
6	Соёлын боловсролын сургалт (эх хэл, аман уламжлал, язгуур соёл, зан үйл, тоглоом наадгай, уриа дуудлага, байгалийн болон сав шим ертөнцийн мэдлэг ухаан, уламжлалт технологи, мал маллах арга ухаан (Монгол малчны эрдэм), уламжлалт гар урлал амьдрах ухаан, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах шавь сургалт явуулах)	Соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд 5-аас доошгүй байх		Соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд 10-аас доошгүй байх		
7	Мэдээ, мэдээлэл (төр засгийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг танин мэдүүлэх, сурталчлан ойлгуулах г.м)	+	+	+	+	+
8	Хурал, уулзалт	+	+	+	+	+
Гурав. Соёлын өв-соёлын аялал жуулчлалын үйлчилгээ						
1	Сумын музей	Байнгын болон түр үзүүлэг дэглэлтийг тогтмол зохион байгуулах				
2	Соёлын өвийн мэдээллийн сан бүрдүүлэх (соёлын өвийг цуглуулах, баримтжуулах, бүртгэх)	Хагас, бүтэн жилээр 2 удаа бүрдүүлж, аймаг, нийслэлийн бүртгэл мэдээллийн санд хүргүүлэх				
3	Тур оператор компанитай хамтран соёлын аялал жуулчлалын маршрут гаргаж бүс нутгийн онцлог бүхий соёл, бүтээлч аялал жуулчлалыг хөгжүүлэх	±	±	±	±	±
Дөрөв. Соёлын бүтээлч үйлдвэрлэл						
1	Уламжлалт гар урлал, технологи (арьс боловсруулах уламжлалт технологи, уламжлалт гар урлал: дээл хувцас, оёдол хатгамал, арьсан урлал, төмөр урлал, дархны урлал, модон тэрэг урлал гэх мэт)	±	±	±	±	±
Тав. Нэмэлт үйлчилгээ						
1	Интернэтийн үйлчилгээ, wifi	+	+	+	+	+
2	Бэлэг дурсгал, бичиг хэргийн худалдаа	+	+	+	+	+
3	Кофе шоп, түргэн хоолны үйлчилгээ	±	±	+	+	+
4	Энтертайнмент үйлчилгээ	±	±	+	+	+
5	Түрээсийн үйлчилгээ	+	+	+	+	+

ТАЙЛБАР:

- + Заавал шаардлагатай
- ± Заавал шаардлагагүй, хавсарч гүйцэтгэж болох
- Шаардлагагүй

Е.3 Соёлын үйлчилгээг төлбөртэй болон хөнгөлөлттэй (төлбөргүй) гэсэн хэлбэрээр үзүүлнэ.

Е.3.1 Хөнгөлөлттэй (төлбөргүй) үнээр үйлчилгээ үзүүлэхдээ дараах зүйлсийг харгалзана.

Е.3.1.1 Хууль, тогтоомжоор зохицуулсан соёлын үйлчилгээг иргэдэд хөнгөлөлттэй (төлбөргүй) үнээр хүргэнэ.

Е.3.1.2 Хууль тогтоомжоор зохицуулаагүй боловч соён гэгээрүүлэх өндөр ач холбогдолтой үйлчилгээг хөнгөлөлттэй (төлбөргүй) үнээр үзүүлж болно.

Е.3.1.3 Гавьяат үйлстэн, Соёлын тэргүүн болон Ардын авьяастан цол тэмдэгтэн, соёлын өвийг хамгаалагч, ахмад настан, нийгмийн эмзэг болон тусгай бүлгийн иргэдэд хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлж болно.

Е.3.1.4 Соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжигч байгууллага, аж ахуй нэгж, иргэнд нотлох баримтын дагуу хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчилгээ үзүүлж болно.

F хавсралт
(мэдээллийн)

Байгууллагын орон тооны жишиг

№	Албан тушаалын нэр	Хүчин чадал (үзэгчийн суудлаар)				
		250 хүртэлх	251-ээс 350	351-ээс 400	401-ээс 500	501-ээс 600
Захиргаа, аж ахуйн ажилчид						
1	Дарга	+	+	+	+	+
2	Нэгжийн дарга	-	-	-	+	+
3	Нягтлан бодогч	±	±	±	±	+
4	Менежер	+	+	+	+	+
5	Маркетингийн менежер	+	+	+	+	+
6	Хүний нөөцийн ажилтан	±	±	±	±	±
7	Архив-бичиг хэргийн эрхлэгч	+	+	+	+	+
Мэргэжлийн ажилчид						
8	Багш (соёл, урлагийн боловсрол)	+	+	+	+	+
9	Арга зүйч (соёл, урлагийн боловсрол)	±	±	±	±	±
10	Номын санч (зөөврийн, танхимын)	+	+	+	+	+
11	Ном зүйч	-	-	-	+	+
12	Номын сангийн арга зүйч	-	-	-	±	±
13	Сүлжээний инженер	-	-	-	±	±
14	Программист	-	-	-	±	±
15	Ном ангилагч, данслагч	-	-	-	±	±
16	Ном сэлбэн засагч	-	-	-	±	±
17	Бүртгэл мэдээллийн санч (музей, соёлын өв)	±	±	+	+	+
18	Музейн сан хөмрөгч	+	+	+	+	+
19	Музейн эрдэм шинжилгээний ажилтан	-	-	-	±	±
20	Компьютер графикч	-	-	-	±	±
21	Дууны инженер	±	±	±	±	±
22	Зураач	-	-	-	±	±
23	Хөгжим хөглөгч	-	-	-	±	±
24	Бүжигчин	-	-	±	±	±
25	Жүжигчин	-	-	±	±	±
26	Дуучин	-	-	±	±	±
27	Хөгжимчин	-	-	±	±	±
28	Нярав	±	±	±	±	±
Үйлчилгээний ажилчид						
29	Тасалбар шалгагч, түгээгч	±	±	±	±	±
30	Тайзны ажилтан	±	±	±	±	±
31	Кино-техникийн ажилтан	+	+	+	+	+
32	Техникч (хөгжмийн, гэрлийн, дэлгэцийн)	+	+	+	+	+
33	Оёдолчин	-	-	±	±	±
34	Үйлчилгээний ажилтан	МКВ	МКВ	МКВ	МКВ	МКВ
35	Сантехникч	+	+	+	+	+
36	Харуул хамгаалалтын ажилтан	+	+	+	+	+

ТАЙЛБАР:

- + Заавал шаардлагатай
- ± Заавал шаардлагагүй, хавсарч гүйцэтгэж болох
- Шаардлагагүй